


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-15 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **1040** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1040 тохиолдлын 93% /972/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 7% /68/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/, Дорноговь /2/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 298 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН 15 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.04.06 - 04.12)


2025 оны эпидемиологийн 15 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын 80 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй ижил байгаа ба сүүлийн 5 жилийн дунджаас 86%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ


Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-15 дугаар долоо хоногт нийт 280** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

140 Эмнэлгийн тусламж авч буцсан	140 Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан	0 Нас барсан	Эрэгтэй 46%	Эмэгтэй 54%
---	--	------------------------	-----------------------	-----------------------



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 15 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **23** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 36%-аар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 85%-аар өссөн байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 15 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	6	9
2	Эмийн хордлого	13	1	14
Нийт		16	7	23

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд 63%- ийг эмэгтэй, 37% -ийг эрэгтэй хүмүүс эзэлж, 19-өөс 56 насныхан байна. **Санамсаргүйгээр** өртсөн тохиолдлуудын 77%-ийг насанд хүрэгчид эзэлж байгаа ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай шингэнийг андуурч ууж хордсон байна.

-o0o-